

Ерөнхий нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн, Александр Агиймаа

2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Салбарын бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, санхүү, хөрөнгийн удирдлага, зохицуулалт, төсөв, санхүүгийн мэдээллээр хангах, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, батлагдсан хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэлийг хянах, үр дүнг тайлагнах;							
1	Байгууллагын санхүү, төсвийн асуудлыг эрхлэн гүйцэтгэж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг явуулна.	Хэрэгжилтийн явц, хувиар	2024 оны байдлаар гадаад, дотоодын байгууллагуудтай байнгын хамтын ажиллагаатай ажиллаж байна.	Байгууллагын дотоод үйл ажиллагааг 100 хувьд хүргэнэ. /Дээшлүүлсэн хувь -100 хувь/	Монгол улсын "Төсвийн тухай" хуулийн 8.9.1 дүгээр зүйл, "Нягтлан бодох бүртгэл"-ийн тухай хууль болон бусад холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах аргачлал, Эдийн засаг, хөгжлийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны 2024 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/-ийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, авлага, өглөг, бараа материал, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн тайлангуудын тохируулга, аккруэл суурьт шалгах балансыг хийж 2025 оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид тус тус хүргүүлж тайлагнав. Хавсралт: 1 файлаар</p> <p>Хавсралт: 1 файл</p>		
2	Байгууллагын шилэн дансны	Шилэн дансны мэдээллийг	Тухай бүр мэдээлэл	Тайланг тухай бүр хугацаанд	Байгууллагын шилэн дансны мэдээллийг	1-р сар, 2-р сар,	100%

	<p>мэдээлэл оруулна.</p>	<p>хугацаанд оруулсан байх, хувиар</p>	<p>оруулсан.</p>	<p>www.shiilendans.gov.mn сайтад байршуулна. /100 хувь/</p>	<p>төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн байгууллага гэсэн 2 ангиллаар ахлах нягтлан бодогчид хамаарагдах жил бүр-6, хагас жил-4, сар бүр-2, тухай бүр-5 хэсгийн мэдээллийг оруулахаас сар болон тухай бүрийн мэдээллийг цаг хугацаанд оруулсан болно. Тухай бүрдээ шилэн дансанд доорх байдлаар ил тод болгож оруулсан: 1. Сар бүрийн төсвийн хөтөлбөр, зориулалтаар батлагдсан төсөв гүйцэтгэл хэмнэлт хэтрэлтийн тайлан 2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 3. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 4. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын</p>	<p>3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	
--	--------------------------	--	------------------	---	---	--	--

					үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт 5. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн тухайн сард шилэн дансны мэдээллийн хугацаандаа мэдээлсэн болно. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 118 харилцагчийн 4,319.0 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг ил тод болгож илтгэсэн.		
3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, санхүүгийн тайланг нэгтгэн гаргана.	Гүйцэтгэл хувиар	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, санхүүгийн тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн.	Тухай бүр хэрэгжүүлж ажилласан байна. /6 тайлан/	Монгол улсын "Төсвийн тухай" хуулийн 8.9.5 дүгээр зүйл, "Нягтлан бодох бүртгэл"-ийн тухай хууль болон бусад холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>аргачлал, Эдийн засгийн хөгжлийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу Монгол улсын Тэргүүн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусган хөтөлж, жилийн эцсийн санхүүгийн болон</p>		
					<p>төсвийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж санхүүгийн этайлан системд хугацаанд шивсэн болно. Жилийн эцсийн санхүүгийн тайланг улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дүн, улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүн, и төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл баталгаа гаргах, арилжааны банкны дансны үлдэгдэл, ТЭЗ-ийн 2024 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрсэн</p>		

					<p>үр дүнгийн талаарх чанарын тоон үзүүлэлт, кассын зарлагын нэгтгэл, төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгах, фрийбаланс программын гүйцэтгэлтэй тулган шалгах, санхүүгийн тайланг шалгуулж Сангийн яамны төрийн сан, хөрөнгө оруулалтын хэлтэстэй тойрох хуудсаар тооцоо нийлсэн. Яамны урсгал санхүүжилт болон хөрөнгө оруулалтын 2025 оны хагас жилийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/-ийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг хийж 2025 оны 09 дүгээр сарын 10-аас 10 дугаар сарын 3-ны дотор үндэсний аудитад баримт болон файлаар мэдээлэл бэлтгэн өгч шалгуулсан.</p>		
4	Улсын төсвийн хөрөнгө	Санхүүжилтийн явц, хувиар	-	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын	1-р сар, 2-р сар,	100%

<p>оруулалтаар шинээр болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийг тухай бүрд нь хянан, санхүүжилтийг шуурхай олгох арга хэмжээ авна.</p>			<p>болон шилжин хэрэгжих төслийн ТЭЗҮ, зураг төсвийн гүйцэтгэлийн санхүүжилтийг тухай бүрд нь хянан, санхүүжилтийг олгосон байна. /100 хувь/</p>	<p>төслийн гүйцэтгэлийг хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын барьцаа, техник хяналтын данстуудаар авч үзэхэд: - ХО-ИЗ /66300/ дансны Шинжлэх ухаанаас шилжин ирсэн 2 төслийн 14,552.0 сая төгрөгийн эрх нээлгэснээс 14,235.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 2025 оны ШУ-ны 1 төслийн 4,950.9 сая төгрөгийн эрх нээлгэснээс 4,950.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 2025 оны ТЭЗҮ-н 9 төслийн 1,198.5 сая төгрөгийн эрх нээлгэснээс 1,196.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, концессийн 10,983.4 сая төгрөгийн эрх нээлгэснээс 10,983.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй нийт 31,365.5 сая гүйцэтгэлтэй гарсан. ХО-ын ЛОТ/ концессын гэрээгээр 26,699.7 сая төгрөгийн орлого орж ирснийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн болно. - Хөрөнгө оруулалтын</p>	<p>3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар</p>	
---	--	--	--	--	--	--

					барьцаа /66350/ дансанд 73 төслийн 81,454.8 сая төгрөгийн эрх нээлгэснээс 57 төслийн 23,178.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд улсын төсөвт 7 төслийн 6,644.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Барьцаа хөрөнгийн дансанд 15 төслийн 199.9 сая төгрөгийн барьцаа суутган байршуулж, 40 төслийн 275.7 сая төгрөгийг суутган техник хяналтын зардлын данс руу шилжүүлэн байршуулсан. -ХО- Техник хяналт /66370/ -ын дансанд 40 төслийн гүйцэтгэлээс суутгал хийгдсэн 275.7 сая төгрөгийн техникийн зардлыг барьцаа данснаас нэмж орлогдсон бөгөөд бүрэн дуусгавар болсон техник хяналтын зардлын хяналт тавьсан байгууллагууд болох БХТ-д 3 төслийн 21.4 сая, ЗТЯ-д 8 төслийн 97.1 сая, НЗХГ-т 10	
--	--	--	--	--	---	--

					төслийн 90.0 сая, Завхан аймгийн ЗДТГ-т 1 төслийн 8.4 сая, Дархан-уул аймгийн ЗДТГ-т 1 төслийн 14.4 сая төгрөгөөр нийтдээ 231,5 сая төгрөгийн гүйцэтгэлийг олгосон. ШУ-ны төслийн зохиогчийн хяналтын зардлыг хянан тооцож Жаргалант хийц ХХК-д 139.6 сая төгрөгийг олгосон. Мөн тус дансны өмнөх оны үлдэгдэлээс концессийн 1 төслийн 1,420.4 сая төгрөгийн гүйцэтгэл олгож улсын төсөвт 1,125.7 сая төгрөгийн аудитын актын дагуу улсын төсөвт татан төвлөрүүлсэн.		
5	Яамны албан хаагчдын цалин, тэтгэмжийг бодож олгох, нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварын тайлангуудыг хянаж баталгаажуулна. НДШ, ХХОАТ-ын тайланг хагас бүтэн жилээр	Хэрэгжилтийн хувь	Цалин олголт, НДШ, татварын тайлан тухай бүр гаргаж хянан баталгаажуулсан.	Цалин олголт, НДШ, татварын тайлан тухай бүр гаргаж хянан баталгаажуулна.	Эдийн засаг, хөгжлийн яамны албан хаагчдын цалин бодолт, нийгмийн даатгалын тайлан, ХХОАТ-ын тайланд хяналт тавьж холбогдох тооцооны нягтлан бодогчид ажил үүргийн чиглэл өгч ажилласан. Яамны цалинг 2025 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	<p>нэгтгэж балансд тайлагнах /100 хувь/</p>				<p>өссөн дүнгээр нийт 123 албан хаагчдад цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал бодож олгохдоо 4,900.6 сая төгрөгийн батлагдсан төсвөөс үндсэн цалинд 2,981.1 сая, нэмэгдэлд 846.0 сая, унаа хоолонд 849.5 сая, урамшуулалд 217.4 сая нийт 4,894.1 сая төгрөгийн 99,9 % гүйцэтгэлтэй гарсан байна. Нийгмийн даатгалд 139 албан</p>		
					<p>хаагчийн ажил олгогчоос 621.9 сая төгрөг даатгуулагчаас 574.7 сая төгрөг нийт 1,196.6 сая төгрөгийг, татварын албанд ХХОАТ-ын 329.2 сая төгрөгийг тус тус тооцож шилжүүлэн хуулийн хугацаанд нь тайлагнаж өр төлбөр үлдэгдэлгүй болно. Сар бүр албан хаагчдын ажлын цагийн тооцооллыг</p>		
					<p>erp-mongolia системээс бодит байдлаар хүн нэг бүрчлэн тулгалт хийж бүртгэн цалин бодсон бөгөөд ажлын ирцтэй</p>		

					холбоотой асуудлуудыг ажилтан бүртэй холбогдож тодруулан уг системийг мөрдөн ажиллах зааварчилгаа өгч цалингийн мэдээллийг албан хаагчдад мэйлээр хүргүүлсэн болно.		
6	Яамны хөрөнгийн тооллогыг хянаж чиглэл өгч ажиллана.	Тооллого хийх тоо /тоо/	2024 оны үндсэн хөрөнгийн тооллого хийж баталгаажуулсан.	Яамны хөрөнгийн тооллогыг хагас болон бүтэн жилээр чиглэл өгч ажилласан байна. / 2 тооллого/	Албаны хэрэгцээнд ашиглагддаг хөрөнгийн хөдөлгөөнд болон өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна. Энэ онд ЗГХЭГ-аас ТӨБЗГ-ын 2025.10.09-ны өдрийн 475 тогтоолоор 60.5 сая төгрөгийн 17 нэр төрлийн 25 ширхэг тоног төхөөрөмжийг балансаас баланс луу шилжүүлэн орлогод авсан. Мөн ТӨБЗГ-т бүтцийн өөрчлөлтөөр шилжсэн Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд 16 нэр төрлийн 23 ширхэг 88.4 сая төгрөгийн хөрөнгийг, салбар нэгж болон гарсан ТХХТөвд 9 нэр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>төрлийн 48 ширхэг 101.9 сая хөрөнгийг балансаас балансын хооронд шилжүүлэх хүсэлтээ хүргүүлсэн байгаа. Яамны худалдан авалтыг бүртгэхдээ хөрөнгө, бараа материалын нэршил болон кодчиллыг нэг хэв загвартайгаар боловсруулан бэлдэж хийсэн бөгөөд хагас жилийн үндсэн хөрөнгийн тооллогыг газар, хэлтэс, хүн тус бүрээр нь шинэчилсэн хөрөнгийн кодчилолтой тулгалт хийж нүдээр харж гараар барин тоолж тооцоо бодолт хийсэн. Жилийн эцсийн тооллогыг эхлүүлэн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн гарсан тухай бүрд тусгай наалттай цаасан дээр эзэмшигчийн нэр, барааны нэр, дүн бар кодтойгоор хэвлэж нааж баталгаажуулан тооцоо бодсон актыг өмч хамгаалах комиссоор оруулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Үүнд: эвдэрч ашиглах боломжгүй</p>		
--	--	--	--	--	--	--	--

						үлдэх өртөггүй болсон 4 нэр төрлийн 8 ширхэг 1.5 сая төгрөгийн тавилга эд хогшлыг, 26 нэр төрлийн 33 ширхэг 112.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг, 2 нэр төрлийн 2 ширхэг 17.9 сая төгрөгийн биет бус үндсэн хөрөнгийг нийт 131.9 сая төгрөгийн хөрөнгийг актлахаар санал оруулахаар, 201 ширхэг 332.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн хугацааг сунгаж дахин үнэлэхээр тус тус санал оруулж байгаа болно.		
7	Худалдан авах ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг сар бүр гаргах	сар гаргасан /тоогоор/	бүр байх	2024 онд худалдан авах ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг сар бүр гаргаж тайлагнасан.	Худалдан авах ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг сар бүр гаргах /12 удаа/	ЭЗХЯ-ны 2025 онд батлагдсан хөтөлбөрт арга хэмжээний зардлаас худалдан авах бараагаар 11 нэр төрлийн зардлын 730.8 сая төгрөгийн төсвөөс 438.4 сая төгрөг буюу 60 % гүйцэтгэлтэй, ажлаар 1 нэр төрлийн зардлын 18.0 сая төгрөгийн төсвөөс 17.9 сая төгрөгийн буюу 99.7 % гүйцэтгэлтэй,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>үйлчилгээгээр 42 нэр төрлийн зардлын 984.3 сая төгрөгийн төсвөөс 613.0 сая төгрөгийн буюу 62.3 % гүйцэтгэлтэй нийт 54 нэр төрлийн зардлын 1,733.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөс 1,069.3 сая төгрөгийн буюу 62%-н гүйцэтгэлтэй хүлээгэж буй гүйцэтгэл 207.5 сая төгрөг буюу 12 % зарцуулаагүй гүйцэтгэл буюу төсвөөс үлдсэн хэмнэлт нь 456.2 сая төгрөг буюу 26% гарч ажилласан байна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу зардлын ангилалаар нь авч үзвэл ЭШС-ны зардал нь 5 нэр төрлийн ажлын 170.0 сая төгрөгийн төсвөөс 104.4 сая төгрөгийн буюу 61.4% гүйцэтгэлтэй, мэдээлэл судалгааны зардал нь 3 нэр төрлийн зардлын 96.0 сая төгрөгийн төсвөөс 44.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 46.8% гүйцэтгэлтэй, мэдээлэл технологийн</p>		
--	--	--	--	--	---	--	--

					<p>үйлчилгээний зардал нь 28 нэр төрлийн зардлын 592.7 сая төгрөгийн төсвөөс 369.5 сая төгрөгийн буюу 62.3% гүйцэтгэлтэй, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардал нь 13 нэр төрлийн зардлын 453.8 сая төгрөгийн төсвөөс 328.0 сая төгрөгийн буюу 73.3% гүйцэтгэлтэй, багаж техник хэрэгслийн зардал нь 5 нэр төрлийн зардлын 420.5 сая төгрөгийн төсвөөс 222.3 сая төгрөгийн буюу 52.9% гүйцэтгэлтэй тус тус гарсан. Худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын аргаар авч үзвэл Ерөнхий гэрээгээр 1 нэр төрлийн зардлын 180.0 сая төгрөгийн төсвөөс гүйцэтгэл гараагүй, Нэг эх үссвэртэй худалдан авалтаар 12 нэр төрлийн зардлын 219.0 сая төгрөгийн төсвөөс 165.4 сая төгрөгийн буюу 75.5%</p>	
--	--	--	--	--	---	--

					гүйцэтгэлтэй, Нээлттэй худалдан авалтаар 3 нэр төрлийн зардлын 498.4 сая төгрөгийн төсвөөс 412.8 сая төгрөгийн буюу 82.8% гүйцэтгэлтэй, Харьцуулалтын аргаар 9 нэр төрлийн зардлын 448.0 сая төгрөгийн төсвөөс 213.6 сая төгрөгийн буюу 47.7% гүйцэтгэлтэй, Шууд худалдан авалтаар 29 нэр төрлийн зардлын 387.0 сая 71,6% гүй		
8	Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулах шийдвэр, албан бичгийн төслүүдийг боловсруулан баталгаажуулах	Гүйцэтгэлийн явц, хувиар	2024 онд тухай бүр удирдлагаас хувиарласан байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулах шийдвэр, албан бичгийн төслүүдийг боловсруулан баталгаажуулсан.	Удирдлагаас хувиарласан байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулах шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр боловсруулна	ЭЗХЯ-ны урсгал санхүүжилтийн хөтөлбөрийн зардлыг тухай бүр санхүүжилтийн эрх нээх, гаалийн нэмэгдсэн болон өртгийн албан татвараас чөлөөлүүлэх хүсэлтийн албан бичиг, орлогын залруулга хийх хүсэлт, хөрөнгө оруулалтын техник хяналтын зардлын зарцуулалт гаргах албан бичиг гэх мэт санхүүгийн тооцоололтой	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					холбоотой бүхий л холбоотой албан бичгүүдийг боловсруулан хянуулж Сангийн яам руу хүргүүлдэг. Энэ онд нийт 40 ширхэг албан бичиг боловсруулалт хийн хянуулж хүргүүлсэн байна.		
9	Монгол улсын засгийн газрын гадаа, зээл тусламжийн удирдлагын мэдээллийн системд тухай бүр /харьяа салбаруудаас хүсэлт ирсэн тохиолдолд/ мэдээлэл оруулж хөтлөх	Тухай бүр, гүйцэтгэлээр	2024 онд монгол улсын засгийн газрын гадаа, зээл тусламжийн удирдлагын мэдээллийн системд тухай бүр /харьяа салбаруудаас хүсэлт ирсэн тохиолдолд/ мэдээлэл оруулж хөтөлсөн.	Монгол улсын засгийн газрын гадаа, зээл тусламжийн удирдлагын мэдээллийн системд тухай бүр /харьяа салбаруудаас хүсэлт ирсэн тохиолдолд/ мэдээлэл оруулж хөтөлнө.	МУ-ын ЗГ-ын гадаад зээл, тусламжийн удирдлагын системд /ODAMIS/ манай байгууллагын харьяа болох ШУ-ны 3 хүрээлэнгийн 9 удаагийн 7,396.7 сая төгрөгийн нэхэмжлэл бүхий импортоор нийлүүлэгдсэн лабораторийн тоног төхөөрөмж болон туслах хэрэгслүүдийн Монгол Улсын Засгийн Газар, Цөмийн Туршилтыг Бүрэн Хориглох гэрээний байгууллагуудын хооронд байгуулагдсан гэрээний 10 дугаар зүйл, Монгол Улсын нэмэгдсэн өртгийн албан албан татварын тухай хуулийн 13	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					дугаар зүйлийн 13.1.3 дахь "Гадаад улсын Засгийн газар, Олон Улсын байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэг тусламж хөнгөлөлттэй зээлээр авсан барааг албан татвараас чөлөөлнө" гэсэн заалтын дагуу Гаалийн болон НӨАТ-ын татвараас чөлөөлөх бичгийг системд бүртгэн хянан баталгаажуулан Сангийн яам руу хүргүүлсэн.		
10	Эдийн засаг, хөгжлийн яамны болон Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж тайлагнах	Гүйцэтгэл, тоогоор	2024 онд Эдийн засаг, хөгжлийн яамны болон Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж тайлагнсан.	Эдийн засаг, хөгжлийн яамны болон Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж тайлагнана	Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсвийн гүйцэтгэлийн тайлан боловсруулах аргачлал, Эдийн засгийн хөгжлийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны урсгал санхүүжилт болон хөрөнгө оруулалтын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусган хөтөлж, жилийн эцсийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж санхүүгийн этайлан системд хугацаанд шивсэн болно. Жилийн эцсийн санхүүгийн тайланг улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дүн, улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүн,и төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл баталгаа гаргах , арилжааны банкны дансны үлдэгдэл, ТЭЗ-ийн 2024 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрсэн үр дүнгийн талаарх чанарын тоон үзүүлэлт, кассын зарлагын нэгтгэл, төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгах, фрийбаланс программын гүйцэтгэлтэй тулган шалгах, санхүүгийн тайланг шалгуулж Сангийн яамны төрийн сан, хөрөнгө оруулалтын хэлтэстэй тойрох хуудсаар тооцоо нийлсэн.</p>		
--	--	--	--	--	--	--	--

					<p>ЭЗХЯ-ны 2025 оны хагас жилийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/-ийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайланг хийж 09 дүгээр сарын 10-наас 10 дугаар сарын 3-ны дотор үндэсний аудитад баримт болон файлаар мэдээлэл бэлтгэн өгч шалгуулсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /ЭЗХЯ-ны сайдын багц/ ашиглалтад орсон 54 нэр төрлийн 13.933.6 сая төгрөгийн үнэ бүхий ТЭЗҮ, зураг төсвийг хавсралтад заасан холбогдох төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын хөрөнгөд бүртгэх ТӨБЗГ-ын 2025.07.08-ны өдрийн 366 тогтоол гарсан бөгөөд одоогоор 13 төслийн 5,909.3 сая төгрөгийн ТЭЗҮ-г балансаас баланс луу шилжүүлэн бүртгэлээс</p>	
--	--	--	--	--	--	--

					хасалт хийгээд байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /БЯ сайдын багц/ бий болсон 3 нэр төрлийн 83 ширхэг 579.4 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг ТӨБЗГ-ын 2025.10.09-ны өдрийн 461 тогтоолоор орлогдон авч харьяа байгууллагуудад балансаас баланс луу шилжүүлсэн.		
11	Үндэсний аудитын газар болон сангийн яамнаас санхүүжийг хяналт шалгалттай холбоотойгоор шаардсан тайлан мэдээлэл, судалгаа тооцооллыг тухай бүр шуурхай гаргаж өгөх	Тухай бүр, гүйцэтгэлээр	2024 онд үндэсний аудитын газар болон сангийн яамнаас санхүүжийг хяналт шалгалттай холбоотойгоор шаардсан тайлан мэдээлэл, судалгаа тооцооллыг тухай бүр шуурхай гаргаж өгсөн	Үндэсний аудитын газар болон сангийн яамнаас санхүүжийг хяналт шалгалттай холбоотойгоор шаардсан тайлан мэдээлэл, судалгаа тооцооллыг тухай бүр шуурхай гаргаж өгнө	Санхүүгийн явцын болон эцсийн аудитад урсгал санхүүжилт болон хөрөнгө оруулалтын хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй, хураангуй бүртгэл, тайлантай холбоотой баримтууд, батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой баримт материалууд, байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой баримт материалууд, байгууллагын тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөө,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					<p>тайлангууд, байгууллагын үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж, дүрэм журмууд, бүтэц, орон тоо баталсан тушаал, шийдвэр (шинээр батлагдсан), худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ, хэлцэл, түүний хэрэгжилт, гэрээ дүгнэсэн актууд, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, байгууллагын хөрөнгийн хагас жилийн тооллогын бүртгэл, дүн, илтгэх хуудас, авлага, өр төлбөрийн тооцоо үүсгэсэн баримт, тооцоо нийлсэн акт, эзэн холбогдогчгүй авлага, өр төлбөрийн судалгаа, өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлт, мэргэжлийн байгууллагын шалгалтын дүгнэлт, тайлан /СЯ, МХГ,</p>		
--	--	--	--	--	--	--	--

					Татвар, НДЕГ, тооцоо нийлсэн акт , дотоод аудитын нэгж/аудиторын тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, харилцах дансдын үлдэгдлийн баталгаа, цалин, цалингийн нэмэгдэл, ээлжийн амралттай холбоотой тушаал, шийдвэр, цалингийн тооцооны хүснэгт, шилэн дансны мэдээллийн нэгдсэн тайлан гэх мэт баримтуудыг цаасаар болон файлаар бэлтгэж өгсөн. Урсгал санхүүжилт болон хөрөнгө оруулалтын баримтуудын бүрдэлт тулгалт хийж архивын нэгж болгон үдэж хаяглалт хийж жагсаалтаар хүлээлгэж өгдөг. Тухай бүрд өгсөн шаардлагатай судалгааг бэлтгэж хийдэг.		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
---	-----------------	---------------	---------

1	2	3	4
---	---	---	---

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Өөрийн хариуцсан ажлын хүрээнд мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн байх	Сургалтад хамрагдсан байх	Сургалтад хамрагдсан	Сургалтад хамрагдсан байна.	1. Төрийн албаны зөвлөлөөс "Төрийн удирдлага ирээдүй" сэдэвт эрдэм шинжилгээний хуралд 2025.10.10-ны өдөр оролцсон. 2. Сангийн яамны онлайн сургалтаар ТСУЦС, ЭБС-ийн 2025 оны хөгжүүлэлт болон системийн цаашдын төлөвлөгөөт хөгжүүлэлтийн талаарх танилцуулгад оролцсон. 3. MS PowerBI+AI, MS Excel+AI 20 цагийн танхимын практик сургалтад маш үр өгөөжтэйгөөр хамрагдаж оролцон сертификат авсан. 4. Сангийн яамнаас зарлагдсан санхүүтэй холбогдсон бүхий л программ сайтуудын тухайлбал finance.gov.mn , pimis.publicinvestment.gov.mn , odamis.mof.gov.mn , shilendans.gov.mn , prod.payrol.gov.mn сайтуудын өөрчлөлт шинэчлэлт орсон тухай бүрд цахимаар хамрагдан байнга оролцсон.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тухай бүр	Мэдээллийн цагт хамрагдсан байх	Мэдээллийн цагт тухай бүр хамрагдсан.	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тухай бүр	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тухай бүр хамрагдсан. 1.Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын газраас явуулсан гамшгаас хамгаалах онолын, практик болон тактикийн сургалтуудад	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар	100%

	хамрагдсан байх			хамрагдана	<p>2025.01.31-ны өдөр хамрагдсан. 2. Монгол Улсын Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү, референт 3.Соёлмаа нар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн талаарх сургалтад 2025.03.27-ны өдөр хамрагдсан. 3. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Дэд захирал, Доктор(Ph.D) Н.Алтанзул “Ажил, амьдралын тэнцвэр” сэдэвт сургалтад 2025.04.25-ны өдөр хамрагдсан. 4. "Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чадавх, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж" сэдвээр Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, Профессор Бадгарын Батцэцэгийн мэдээллийн цагт 2025.11.07-ны өдөр хамрагдсан. 5. Макро эдийн засгийн бодлогын газар- “АНУ-Д СУРАЛЦАХ БОЛОМЖ” мэдээллийн цагт хамрагдсан.</p>	сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	-----------------	--	--	------------	---	--	--

ХЯНАСАН:

Санхүүгийн хэлтсийн дарга, Жаргалсайхан Гэрэлбат /...../

Огноо: 2025.12.15

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ерөнхий нягтлан бодогч, ахлах мэргэжилтэн, Александр Агиймаа /...../

Огноо: 2025.12.15

